



МОНГОЛ УЛС
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2016 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

Сонгуулийн баримт бичгийг бүртгэх,
цэгцлэх, хүлээлцэх журам батлах тухай

Сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.14, 34 дүгээр зүйлийн 34.1.14, 35 дугаар зүйлийн 35.7.6 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3, 12.6 дахь хэсгийг тус тус үндэслэн Сонгуулийн Ерөнхий Хорооноос ТОГТООХ нь:

1. “Сонгуулийн баримт бичгийг бүртгэх, цэгцлэх, хүлээлцэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг хэрэгжүүлж ажиллахыг Сонгуулийн хороодын дарга нарт, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Сонгуулийн Ерөнхий Хорооны нарийн бичгийн дарга /Ц.Болдсайхан/-д тус тус даалгасугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Сонгуулийн Ерөнхий Хорооны 2012 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 13 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Сонгуулийн баримт бичгийг бүртгэх, хүлээлцэх” журам, 2012 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 149 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Сонгуулийн баримт бичиг, түүнийг бүртгэх, цэгцлэх, хүлээлцэх” журам, 2013 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 06 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн баримт бичгийг бүртгэх, цэгцлэх, хүлээлцэх журам батлах тухай” журмуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА

Ч.СОДНОМЦЭРЭН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ц.БОЛДСАЙХАН

Сонгуулийн Ерөнхий Хорооны
2016 оны 04 дугаар сарын 26-ны өдрийн
30 дугаар тогтоолын хавсралт



СОНГУУЛИЙН БАРИМТ БИЧГИЙГ БҮРТГЭХ, ЦЭГЦЛЭХ, ХҮЛЭЭЛЦЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Сонгуульд хамаарах баримт бичгийг /цаашид “баримт бичиг” гэх/ бүртгэх, цэгцлэх, хүлээлцэх үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Сонгуулийн байгууллагууд энэ журмын 2.1-д заасан нийтлэг баримт бичгүүдээс гадна тус тусын чиг үүрэгт хамаарах баримт бичгүүдийг бүртгэн цэгцэлж, санал хураалт дууссаны дараа энэ журамд заасан хугацаанд санал авах байр нь сум, дүүргийн сонгуулийн хороонд, сум, дүүргийн сонгуулийн хороо аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд аймаг, нийслэлийн сонгуулийн хороо Сонгуулийн Ерөнхий Хороонд тус тус хүлээлгэн өгнө.

Хоёр. Сонгуулийн хороодын бүртгэх, цэгцлэх нийтлэг баримт бичиг

2.1. Сонгуулийн хороодын бүртгэх нийтлэг баримт бичигт дараах баримт бичгүүд хамаарна:

2.1.1. Сонгуулийн хороод болон санал авах байрын бүрэлдэхүүнийг томилсон шийдвэр, ажлын төлөвлөгөө, тайлан;

2.1.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороодын хуралдааны тэмдэглэл, түүнд хавсаргасан баримт бичиг;

2.1.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороодын тогтоол;

2.1.4. Сонгуулийн зардлын санхүүгийн баримт, тайлан;

2.1.5. Сонгуулийн байгууллагад ирсэн, явсан баримт бичиг;

2.1.6. Өргөдөл, гомдол, мэдээлэл, тэдгээрийг шийдвэрлэсэн баримт бичиг;

2.1.7. Санал тоолох төхөөрөмжөөс хэвлэгдсэн санал хураалтын дүн, түүний нэгтгэл;

2.1.8. Саналын хуудас хүлээн авсан болон зарцуулалтын тайлан, мэдээ;

2.1.9. Ирцийн мэдээ болон санал өгсөн сонгогчдийн нас, хүйсийн судалгаа;

2.1.10. Санал тоолох төхөөрөмжийн иж бүрдлийг хүлээлцсэн баримт;

2.1.11. Бусад баримт бичиг.

Гурав. Сонгуулийн баримт бичгийг бүртгэх, цэгцлэх

3.1. Сонгуулийн Ерөнхий Хороо дараах баримт бичгүүдийг бүртгэж цэгцлэнэ:

3.1.1. Сонгууль зохион байгуулалтын асуудлаар гаргасан Улсын Их Хурлын шийдвэр;

3.1.2. Сонгуулийн Ерөнхий Хорооны тогтоол, даргын захирамж;

- 3.1.3. Сонгуулийн төсөв, тооцоо, судалгаа;
- 3.1.4. Сонгуулийн хэсгийн судалгаа;
- 3.1.5. Гадаад улсад байгаа сонгогчдын санал авахад хэрэглэж битүүмжилсэн хүчинтэй болон хүчингүй саналын хуудас;
- 3.1.6. Сонгуульд оролцох нам, эвсэл, хамтарсан намуудын бүртгэл, түүнд холбогдох баримт бичиг;
- 3.1.7. Нэр дэвшигчийн бүртгэл, түүнд холбогдох баримт бичиг;
- 3.1.8. Нам, эвсэл, хамтарсан намуудын сонгуулийн штабын ажилтан, нэр дэвшигчийн менежер, шадар туслагч, ухуулагчийн бүртгэл түүнд холбогдох баримт бичиг;
- 3.1.9. Сонгуулийн зардал, түүний тайлан, аудитын байгууллагын дүгнэлт;
- 3.1.10. Саналын хуудасны загвар, тоог батлах, саналын хуудсыг хэвлүүлэх, хуваарилахтай холбогдсон баримт бичиг;
- 3.1.11. Гадаадын ажиглагчийн бүртгэл, түүнд холбогдох баримт бичиг;
- 3.1.12. Санал тоолох төхөөрөмжөөс хэвлэгдсэн санал хураалтын дүн; түүний нэгтгэл;
- 3.1.13. Сонгуулийн автоматжуулсан системийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, программ хангамжийн бүртгэл, холбогдох баримт бичиг;
- 3.1.14. Бусад баримт бичиг;

3.2. Аймаг, Нийслэлийн сонгуулийн хороо дараах баримт бичгүүдийг бүртгэж цэгцлэнэ:

- 3.2.1. Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны тогтоол, даргын захирамж;
- 3.2.2. Сонгууль зохион байгуулах ажлын болон авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө;
- 3.2.3. Улсын болон орон нутгийн төсвөөс хуваарилсан төсвийн хөрөнгийн зарцуулалтын тайлан;
- 3.2.4. Аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд саналын хуудас хүлээн авсан тэмдэглэл, түүнийг хуваарилах, хүргүүлэхтэй холбогдсон баримт бичиг;
- 3.2.5. Нэр дэвшигчийн менежер, шадар туслагч, ухуулагчийн бүртгэл, түүнд холбогдох баримт бичиг;
- 3.2.6. Санал тоолох төхөөрөмжөөс хэвлэгдсэн санал хураалтын дүн, түүний нэгтгэл;
- 3.2.7. Сонгогчдын санал авахад хэрэглэсэн битүүмжилсэн хүчинтэй, хүчингүй саналын хуудас;
- 3.2.8. Сонгуулийн хорооны шийдвэртэй холбогдсон болон бусад өргөдөл, гомдол, тэдгээрт холбогдох баримт бичиг;
- 3.2.9. Бусад баримт бичиг.

3.3. Сум, дүүргийн сонгуулийн хороо дараах баримт бичгүүдийг бүртгэж цэгцлэнэ:

- 3.3.1. Сум, дүүргийн сонгуулийн хорооны тогтоол, даргын захирамж;
- 3.3.2. Сонгогчдын нэрийн жагсаалт;
- 3.3.3. Санал тоолох төхөөрөмжөөс хэвлэгдсэн санал хураалтын дүн, түүний нэгтгэл;
- 3.3.4. Санал авах байрын ахлах зохион байгуулагч болон зохион байгуулагчдийн томилсон тухай шийдвэр, бүрэлдэхүүний талаарх мэдээлэл;
- 3.3.5. Сонгуулийн ажлын зохион байгуулалттай холбогдсон бусад баримт бичиг;

3.3.6.Санал авах байранд ажилласан ажиглагчийн бүртгэл, түүнд холбогдох баримт бичиг;

3.3.7.Саналын хуудас, түүнийг хүлээн авсан, хуваарилсан, зарцуулсан тухай холбогдох баримт бичиг;

3.3.8.Улсын болон орон нутгийн төсвөөс хуваарилсан төсвийн хөрөнгийн зарцуулалтын тайлан;

3.3.9.Сонгогчдын санал авахад хэрэглэсэн битүүмжилсэн хүчинтэй, хүчингүй саналын хуудас;

3.3.10.Өргөдөл, гомдол шийдвэрлэсэн мэдээлэл;

3.3.11.Санал авах байрны үйл ажиллагаатай холбоотой бусад бичиг баримт.

3.4.Сонгуулийн баримт бичгийн бүртгэлийг цаг хугацааны дараалал, төрөл тус бүрээр ангилан тусгай дэвтэрт хөтөлнө.

3.5.Сонгуулийн баримт бичгийг холбогдох этгээд бүртгэхдээ тухайн баримт бичигт гарын үсэг зурж, тэмдэг дарсан эсэхийг нягтлан шалгана.

3.6.Сонгуулийн баримт бичгийн бүртгэлийн дэс дугаар, он сар өдөр, доторх агуулгыг өөрчлөх, солих, засвар оруулах, бичигдсэн зүйлийг дарахыг хориглоно.

Дөрөв. Сонгуулийн баримт бичгийг хүлээлгэн өгөх

4.1.Сонгуулийн хороод нь бүртгэсэн баримт бичгээ төрөлжүүлэн цэгцэлж, хүлээлцэхэд бэлтгэсэн байна.

4.2.Санал авах байрны ахлах зохион байгуулагч, зохион байгуулагчид нь Санал тоолох төхөөрөмжийн дүн, түүний нэгтгэлээс бусад энэ журмын 3.3-т заасан холбогдох баримт бичгийг 3 хоногийн дотор сум, дүүргийн сонгуулийн хороонд хүргүүлнэ.

4.3.Сум, дүүргийн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга нь санал тоолох төхөөрөмжийн дүн, түүний нэгтгэлээс бусад энэ журамд заасан баримт бичгийг санал хураалт дууссанаас хойш 5 хоногийн дотор аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд хүргүүлнэ.

4.4.Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга энэ журмын 4.6-д заасан баримт бичгүүдийг бүртгэж санал хураалт дууссанаас хойш 14 хоногийн дотор Сонгуулийн Ерөнхий Хороонд хүргүүлнэ.

4.5.Аймаг, Нийслэлийн сонгуулийн хороо энэ журмын 3.2-т заасан баримт бичгүүдийг аймаг, нийслэлийн архивт хүлээлгэн өгнө. Ингэхдээ энэ журмын 3 дугаар зүйлийн 3.2.7-д заасан баримт бичгийн битүүмжилсэн баглаа боодлыг нь задлахыг хориглоно.

4.6.Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга сонгуулийн дүнгийн тухай хуралдааны тэмдэглэл, ажлын тайлан, нэгдсэн дүн, саналын хуудасны зарцуулалтын тайлан, санал авах байранд санал тоолсон дүнгийн тухай хуралдааны тэмдэглэл, санал тоолох төхөөрөмжөөс хэвлэгдсэн санал хураалтын дүн, түүний нэгтгэл, сонгуулийн зардлын тайлан зэрэг баримт бичгийг Сонгуулийн Ерөнхий Хороонд хүлээлгэн өгнө.

4.7.Бүх шатны сонгуулийн хороод нь сонгуулийн баримт бичгийг хүлээлцсэн тухай тэмдэглэл үйлдэнэ. Архивт хүлээлцэхдээ уг ажиллагаанд байлцсан гишүүд, архивын эрхлэгч тус тус гарын үсэг зурж зохих журмын дагуу хадгална.

Тав. Хариуцлага

5.1.Сонгуулийн тухай хууль болон энэ журамд заасныг зөрчсөн этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

5.2.Сонгуулийн хороод нь сонгуулийн тухай хууль болон энэ журамд заасныг зөрчсөн эсэхийг холбогдох байгууллагад шалгуулахаар хүргүүлнэ.

---oOo---